



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2016 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/539

Мөрөн

Зөвлөгөөн зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дугаар зүйл, 29.1.6-гийн "а" заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 77 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баялаг бүтээгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөгөөний удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 5 сая төгрөгийг "Өрх гэр бүлийн хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрөөс гаргаж зарцуулахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Х.Ган-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт зөвшөөрсүгэй.

3. Зөвлөгөөний бэлтгэлийг сайн хангаж, чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Эрдэнэхуяг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД